



Бичил хиймэл дагуул,
РОВЕР зохион бүтээх
үндэсний тэмцээн



КАНСАТ СЭТГҮҮЛ

ҮНДЭСНИЙ 6 ДУГААР ТЭМЦЭЭНИЙ ТОЙМ

ЭРХЛЭН ГАРГАСАН:

ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИЙН ОДОН ОРОН ГЕОФИЗИКИЙН ХҮРЭЭЛЭН
МОНГОЛЫН САНСРЫН ТЕХНОЛОГИЙН ХОЛБОО ТББ

КАНСАТ 2023 СЭТГҮҮЛИЙН РЕДАКЦИЙН ЗӨВЛӨЛ

Ерөнхий редактор:

Ж.ГҮРРАГЧАА

Гишүүд:

С.ДЭМБЭРЭЛ

Д.ЭРДЭНЭБААТАР

Т.ТӨРТОГТОХ

Т.БЭГЗСҮРЭН

Д.САМБУУ

Д.ХОС-ЭРДЭНЭ

Хэвлэлийн эх бэлтгэсэн:


У.ТӨГӨЛДӨР

2024 он

КАНСАТ

ГЭЖ ЮУ ВЭ?

КАНСАТ (CANSAT) нь хиймэл дагуулын ихэнх шинж чанарыг агуулсан бяцхан төхөөрөмж бөгөөд **"CAN"** – ЛААЗ, **"SATELLITE"** – хиймэл дагуул гэсэн үгнүүдээс бүтсэн **ЛААЗАНД БАГТАХ ХЭМЖЭЭНИЙ БИЧИЛ ХИЙМЭЛ ДАГУУЛ** юм.



**" 1999 онд 12 их сургуулийн 50 оюутан оролцон
эхэлсэн **КАНСАТ** төсөл сансрын хувьсгалын
эхлэл болсон юм. 2022 онд **САНСАРТ** хөөрсөн 2303
хиймэл дагуулын **95% -г** жижиг хиймэл дагуул
эзэлж байна"**



Кансат 2015
» Оролцогч багийн Кансатыг тээсэн цойлуур хөөрөх агшин



Кансат 2016
» Оролцогч багийн Кансатыг тээсэн цойлуур хөөрөх агшин



Кансат 2013
» Тэмцээний нээлт. Ерөнхий эвээн тэтгэгчийн нэрэмжит цойлуур хөөрөх агшин

Сансрын техник технологийг нийгэмд таниулан сурталчлах, оюутан сурагчдын мэдлэг боловсролыг дээшлүүлэх, сансрын технологийг хамтран бүтээж, харилцан суралцах зорилго бүхий "КАНСАТ" тэмцээнийг олон улс орнуудад оюутан залуусын дунд өргөн дэлгэр зохион байгуулж байна. Монгол улсад энэ тэмцээнийг анх 2013 онд Монгол Улсын Ерөнхий сайдын ивээл доор "Хиймэл дагуул-Бидний тэмүүлэл" уриатайгаар зохион байгуулсан бөгөөд 2016 он хүртэл 4 удаагийн үндэсний тэмцээн зохиогдож, түүнээс хойш 2022 он хүртэл зохиогдолгүй түр завсарлаад байсан юм.

Монгол Улсад сансрын технологийг хөгжүүлэх, үндэсний боловсон хүчнийг бэлтгэх, оюутан сурагчид, инженер судлаачид болон олон нийтэд шинжлэх ухааныг таниулан сурталчлах, түгээн дэлгэрүүлэх ач холбогдол бүхий энэ тэмцээнийг 2023 онд Цахим Хөгжил Харилцаа Холбооны Яам, ШУА-ын Одон Орон Геофизикийн Хүрээлэнгийн Сансар Судлалын Төв, Монголын Сансрын

Технологийн Холбоо ТББ, МУИС, ШУТИС, Спэйс Академи, зэрэг байгууллагууд хамтран зохион байгууллаа.

КАНСАТ тэмцээн нь COTS букуу зах зээл дээрээс олдох боломжтой элементүүдийг ашиглан сансрын системийг зохион бүтээх инженерчлэлийн арга барилаар бодит төслийг эхнээс нь дуустал хийж гүйцэтгэн баг хоорондоо өрсөлдөхөөс гадна харилцан бие биеэсээ суралцдаг чухал ач холбогдолтой тэмцээн юм. Тэмцээнд оролцогчид нь хиймэл дагуулын технологи, дэд системүүдийн үүрэг зориулалтын талаар суралцаж, мэдлэг чадвараа дээшлүүлэхийн зэрэгцээ, өөрсдийн зохион бүтээж буй системийн даалгаврыг тодорхойлох, загвар гаргах, турших, угсрах, хөөргөн ажиллуулах, мэдээлэл боловсруулах зэрэг төслийн амьдралын мөчлөг бүрийн үйл явцыг өөрсдөө удирдан биечлэн гүйцэтгэж оролцдоогоороо давуу талтай.

КАНСАТ ТЭМЦЭЭНИЙ МОНГОЛ УЛСАД ЗОХИОГДСОН ТҮҮХЭН ТОВЧООН



Цахим хөгжил, харилцаа
холбооны яам Ерөнхий зохион
байгуулагчаар ажиллаж 6 дахь
удаагаа зохион байгуулав.

2023

Цахим хөгжил, харилцаа
холбооны яам Ерөнхий зохион
байгуулагчаар ажиллаж 5 дахь
удаагаа зохион байгуулав.

2022

Ази, Номхон далайн сансрын
хамтын ажиллагааны
байгууллагатай хамтран олон
улсын уралдаан болгон зохион
байгуулав.

2016

Мэдээллийн технологи, шуудан
харилцаа холбооны газар
үндэсний III тэмцээнийг зохион
байгуулав.

2015

Монгол Улсын Ерөнхий сайдын
ивээл доор үндэсний II тэмцээн
зохион байгуулагдсан.

2014

Монгол Улсын Ерөнхий сайдын
ивээл доор "Хиймэл дагуул-
Бидний тэмүүлэл" уриатайгаар
зохион байгуулагдсан

2013

КАНСАТ 2023



ТЭМЦЭЭНИЙ ДҮРЭМ

КАНСАТ 2023 тэмцээн нь сургалт, хэлэлцүүлэг, уралдаант тэмцээн хосолсон хэлбэрээр явагдаж багууд дөрвөн сарын турш оноо цуглуулан өрсөлдсөн юм. Оролцогч багууд чиглүүлэх сургалтуудад хамрагдаж хөгжүүлэлтийн явцад Даалгавар тодорхойлох, урьдчилсан загварын хэлэлцүүлэг (ДТУЗХ), Шийдвэрлэх загварын хэлэлцүүлэг (ШЗХ), Нисэх бэлэн байдлын үзлэг (НББУ) гэсэн 3-н хэлэлцүүлэгт оролцон 40 оноо цуглуулж, тэмцээний өдөр буюу 5-р сарын 18-нд даалгавраа гүйцэтгэн, үр дүнгийн хэлэлцүүлэгт илтгэн 60 оноо цуглуулж нийлбэр оноогоороо өрсөлдсөн юм. Энэ жилийн тэмцээн нь КАНСАТ болон БУЦАГЧ гэсэн хоёр төрлөөр зохиогдож оюутан залуусын мэдлэг чадвар, авхаалж самбааг сорьсон юм.



КАНСАТ

Лаазанд багтах төхөөрөмж

Оролцогч багууд өөрсдийн тодорхойлсон даалгаврыг гүйцэтгэх 330мл -ийн ундааны лаазанд багтах жижиг хиймэл дагуул хийж цойлуураар дээш хөөргөн, агаарт шүхрээр буцаж бууж ирэх үедээ газрын станцтай холбогдож мэдээлэл дамжуулан даалгавраа гүйцэтгэнэ.



БУЦАГЧ РОВЕР

Өөрөө явагч робот

Оролцогч багууд өөрөө "нисэгч" эсвэл "явагч" зохион бүтээх ба түүнийг тэмцээн зохион байгуулагчийн цойлуур эсвэл агаарын бөмбөлгөөр дээш хөөргөж өндрөөс унагана. Төхөөрөмж аюулгүй газардахаас гадна урьдчилан өгсөн тодорхой солбицол дээр хамгийн богино хугацаанд хүрэх ёстой.

КАНСАТ 2023 ҮНДЭСНИЙ 6-РТЭМЦЭЭНД ДОТООДЫН

9 ИХ, ДЭЭД СУРГУУЛЬ, КОЛЛЕЖИЙН 150 ГАРУЙ ОЮУТАН ЗАЛУУСААС БҮРДСЭН 22 БАГ ӨӨРСДИЙН КАНСАТ БОЛОН БУЦАГЧ РОВЕРУУДАА ЗОХИОН БҮТЭЭЖ АВХААЛЖ САМБАА, ОЮУН УХААН, МЭДЛЭГ ЧАДВАРАА СОРИН





ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

Суралцах, хуваалцах газар

Кансат тэмцээний аливаа хэлэлцүүлэг нь танхимд эрдэм шинжилгээний хурал хэлбэрээр зохион байгуулагддаг. Оролцогч баг тус бүр КАНСАТ эсвэл БУЦАГЧ -ийн хөгжүүлэлтийн үйл явц, туршлага, үр дүнгээ бусад багууд болон шүүгч нарт илтгэж, асуултуудад хариулна.



ШАГНАЛ

Нийт онооны дүнгээр I байр, II байр, III байр, Тусгай номинаци тус бүр нэг багийг шалгаруулна.

- I-р байр: Цом, Өргөмжлөл, (5,000,000)
- II-р байр: Өргөмжлөл, (3,000,000)
- III-р байр: Өргөмжлөл, (1,000,000)
- Тусгай номинаци: Өргөмжлөл, (500,000)

ЗОХИОН БАЙГУУЛАГЧДААС ҮЗҮҮЛЭХ МАТЕРИАЛЛАГ ДЭМЖЛЭГ

- Баг бүрийн КАНСАТ-ыг хөөргөх цойлуур, 200м - 300м өндөрт
- Нэг удаагийн туршилтын нислэг
- КАНСАТ-ын бүтэц, эд ангид орсон 3D загварыг хэвлэж өгөх
- Бусад боломжит дэмжлэг

ТЭМЦЭЭНИЙ ҮЕ ШАТУУД, ОНОО ЦУГЛУУЛАХ ЗАРЧИМ

КАНСАТ тэмцээнд оролцогчид нь ямар ангиллаар өрсөлдөж байгаагаас үл хамааран дараах хоёр үе шаттайгаар шүүгчдээс оноо цуглуулна.

ХӨГЖҮҮЛЭЛТИЙН ҮЕ (40 ОНОО)

Оролцогч багууд нь хөгжүүлэлтийн явцад чиглүүлэх сургалтад хамрагдсан байх ба дараах хэлэлцүүлгүүдэд оролцож, шүүгчдээс оноо цуглуулна.

Үүнд, ДААЛГАВАР ТОДОРХОЙЛОХ, УРЬДЧИЛСАН ЗАГВАРЫН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ 15 оноо, ШИЙДВЭРЛЭХ ЗАГВАРЫН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ 15 оноо, НИСЭХ БЭЛЭН БАЙДЛЫН ҮЗЛЭГ 10 оноо тус тус багтана.

ХӨӨРГӨЛТ, ГҮЙЦЭТГЭЛ (60 ОНОО)

Тэмцээн болох өдөр багууд өөрсдийн хийсэн төхөөрөмжөө хөөргөн, зорьсон даалгавраа биелүүлэхийн төлөө өрсөлдөнө. Оролцогч багуудын тухайн өдрийн амжилт, туршилтын үр дүнг Үр дүнгийн хэлэлцүүлэг дээр танилцуулна. Тэмцээний шүүгчид багуудын гүйцэтгэлийг 60 оноогоор дүгнэн өмнөх хөгжүүлэлтийн үеэс авсан оноог нэмж тэмцээний ялагчийг тодруулна.



ЕРӨНХИЙ ИВЭЭН ТЭТГЭГЧ

КАНСАТ 2023 ҮНДЭСНИЙ 6-Р ТЭМЦЭЭНИЙ ЕРӨНХИЙ ИВЭЭН ТЭТГЭГЧЭЭР "МОНГОЛСАТ НЭТВОРКС" ХХК АЖИЛЛАВ.



"Шинжлэх ухааныг дэмжсэн дэмжсэн Кансат тэмцээнийг ивээн тэтгэхийн гол ач холбогдол нь сансрын технологийг судлах, бүтээх, хөгжүүлэх, ирээдүйн монгол улсыг бүтээх инженерүүд энэхүү тэмцээнээс төрөн гарна гэдэгт итгэлтэй байна. Тэмцээнд оролцож буй эдгээр залуусын хичээл зүтгэл бидний залуу насыг сануулж байна."

Монголсат Нетворкс ХХК -ны ерөнхий захирал Н.БУМЧИН

**"БУЦАГЧ НЬ ИРЭЭДҮЙД
САНСРЫН БИЕТ, БУСАД
ГАРАГ ДЭЭР ДААЛГАВАР
БИЕЛҮҮЛЭХ РОБОТ ЮМ"**

ОРОЛЦОГЧ БАГТ ТАВИГДАХ ШААРДЛАГА

- Тэмцээнд мэдүүлгээ өгч, чиглүүлэх сургалтад хамрагдсан багууд оролцоно.
- Багийн гишүүд нь удирдагч болон 3 –аас доошгүй тооны бүрэлдэхүүнтэй байна. Багийн удирдагч нь заавал насанд хүрсэн хүн байна.
- Нэг оролцогч нэгээс илүү багт харьяалагдахгүй.
- Багууд нь тэмцээнд оролцох мэдүүлгийг загварын дагуу бөглөж 2022 оны 02 сарын 17-ны 23:59 цагаас өмнө info@mosta.mn цахим хаягаар ирүүлнэ.
- Багууд өөрийн гэсэн оноосон нэртэй байна.
- Багууд тэмцээний дараа орчны цэвэр байдлыг хангана.

КАНСАТ-Д ТАВИГДАХ ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

- КАНСАТ нь хөөргөгчид байрлуулахаас өмнө нь 330мл стандартын ундааны лаазны (115мм-ийн өндөртэй, 66 мм-ийн диаметртэй) хэмжээтэй байна. Хөөргөгчөөс салсны дараа өөрийн хэлбэр дүрсийг дурын байдлаар өөрчилж болно.
- КАНСАТ хөөргөгчөөс салсны дараа газарт зөөлөн газардахын тулд нисэх хэрэгслийг (шүхэр) ашиглана. Нисэх хэрэгслийг

КАНСАТ-ын нэг хэсэг гэж үзэхгүй бөгөөд хөөргөгчид байрлахдаа 70мм өндөртэй, 66мм-ийн диаметртэй цилиндр эзлэхүүнд багтах шаардлагатай.

- КАНСАТ-ын нийт масс нь 350 граммаас хэтрэхгүй байна.
- Нисэх хэрэгсэл буюу шүхэр 150 граммаас хэтрэхгүй масстай байна.


БУЦАГЧ-Д ТАВИГДАХ ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

- БУЦАГЧ нь хөөргөгчид байрлуулахаас өмнө нь 230мм –ийн өндөртэй, 130 мм –ийн диаметртэй цилиндрт багтах хэмжээтэй байна. Хөөргөгчөөс салсны дараа өөрийн хэлбэр дүрсийг дурын байдлаар өөрчилж болно.
- БУЦАГЧ хөөргөгчөөс салсны дараа газарт зөөлөн газардахын тулд нисэх хэрэгслийг (шүхэр, далавч гм) ашиглаж болно. Нисэх хэрэгслийг БУЦАГЧ –ын нэг хэсэг гэж үзэхгүй бөгөөд хөөргөгчид байрлахдаа 70мм өндөртэй, 150мм –ийн диаметртэй цилиндр эзлэхүүнд багтах шаардлагатай.
- БУЦАГЧ –ын нийт масс нь 1кг –аас хэтрэхгүй байна.
- Нисэх хэрэгсэл буюу шүхэр 200 граммаас хэтрэхгүй масстай байна.



ТЕХНИКИЙН БАРИМТ БИЧИГ

Кансат 2023 тэмцээнд оролцогч багууд өөрсдийн төхөөрөмжийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл агуулсан техникийн баримт бичиг бэлтгэх шаардлагатай. Энэхүү баримт бичиг нь нийт төслийн үргэлжлэх хугацаанд шинэчлэгдэн сайжирч явах бөгөөд Кансат тэмцээн дууссаны дараа ч тухайн багийн хийсэн бүтээсэн зүйлийг дараа үеийнхэн, олон нийт, оюутан залуус үзэж сонирхох, танилцаж мэдэх боломжтой чухал баримт юм.



ХЭМЖЭЭ БОЛ ХЭМЖЭЭ

Кансат тэмцээнд оролцогч багууд өөрсдийн төхөөрөмжөө бүтээхдээ урьдчилан өгөгдсөн хэмжээ, хязгаар шаардлагыг заавал хангасан бүтээл хийх ёстой. Учир нь тухайн Кансат эсвэл Буцагчийг тээвэрлэн агаарт гаргах цойлууур, агаарын бөмбөлөг зэрэг нь тодорхой масстай ачааг л тооцоолсон өндөрт гаргах боломжтой. Мөн урьдчилан бүтээгдсэн агуулах хэсгийн хэмжээг өөрчлөх боломжгүй байдаг. Иймд шаардлага хангаагүй Кансат эсвэл Буцагч нь хөөрөх боломжгүй юм.



ХУГАЦАА

» Кансат 2023 тэмцээний үйл явдлыг цаг хугацааны дарааллаар тэмдэглэн харуулав.

КАНСАТ 2023 ТЭМЦЭЭНИЙ ШҮҮГЧДИЙН БҮРЭЛДЭХҮҮН



Кансат 2023 тэмцээнд Монгол Улсын Боловсрол Шинжлэх Ухааны Яам, Цахим Хөгжил Харилцаа Холбооны Яам, Шинжлэх Ухааны Академи, Монгол Улсын Их Сургууль гэсэн байгууллагуудаас томилогдсон 3 шүүгч ажилласан бөгөөд Кансат болон Буцагчийн хөгжүүлэлтээс эхлэн хөөргөлт, үр дүнгийн хэлэлцүүлэг хүртэл бүхий л үе шатуудад оролцон мэргэжлийн үнэлэлт, дүгнэлт өгч тэмцээний ялагчдыг тодруулсан юм.



Д.ЗАЯАБАЯР

Цахим Хөгжил, Харилцаа
Холбооны Яам



Б.СУВДАНЦЭЦЭГ

Шинжлэх Ухааны Академийн
Удирдлага Төлөвлөлтийн
Газрын дарга, доктор



Д.ЭРДЭНЭБААТАР

Монгол Улсын Их Сургуулийн
Шинжлэх Ухааны Сургуулийн
дэд профессор, доктор

ДААЛГАВАР ТОДОРХОЙЛОХ УРЬДЧИЛСАН ЗАГВАР




ДААЛГАВАР ТОДОРХОЙЛОХ ХЭЛЭЛЦҮҮЛЭГ НЬ АЛИВАА СИСТЕМИЙН ЗОРИЛГЫГ ТОДОРХОЙЛЖ, ЯМАР ҮҮРЭГ ДААЛГАВАР ГҮЙЦЭТГЭХ, ТҮҮНД ЯМАР ШААРДЛАГУУД ТАВИГДАХЫГ ТОДОРХОЙЛДОГ ХЭЛЭЛЦҮҮЛЭГ ЮМ.

Хиймэл дагуул, систем инженерийн төсөлд **Даалгавар Тодорхойлох Хэлэлцүүлэг (Mission Definition Review / MDR)** нь цаг хугацааны хувьд хамгийн эхэнд болдог. Энэхүү хэлэлцүүлгээр хэрэглэгчийн, системийн, загвар дизайны гэх мэт бүх шаардлагууд тодорхой болно. Үүний дараа тухайн шаардлагуудыг хангасан системийг бүтээхэд хэрэгцээтэй зүйлс, арга технологийг судлан тооцоолж бүтээж буй системийн ерөнхий загвар ямар байхыг урьдчилан гаргаж ирдэг. Үүнийг **Урьдчилсан Загварын Хэлэлцүүлэг (Preliminary Design Review / PDR)**-ээр хэлэлцэнэ. Энэ хэлэлцүүлгээр тухайн систем нь ямар элементүүдийг ашиглах нь

урьдчилсан байдлаар тодорхой болсон байх шаардлагатай. Үүний тулд хиймэл дагуулын Ширээний загвар (хиймэл дагуул шиг хэлбэртэй байх албагүй, ширээн дээр зөвхөн үйлдлийг нь туршихад зориулсан загвар) дэд системийн түвшинд бий болсон байх шаардлагатай.

ИЛТГЭЛ

» Багууд өөрсдийн илтгэл эхлэхээс өмнө үзүүлэнгээ хянаж буй байдал.





ИВЭЭН ТЭТГЭГЧ




"Жил ирэх тусам хүний нөөц олоход төвөгтэй болж буй энэ үед 150 ирээдүйн инженерүүд цуглаад, ур ухаанаа уралдуулж буйд сэтгэл хангалуун байна. Кансат тэмцээн нь энэ салбарт ирээдүйн инженер, мэдлэг, боловсон хүчинг бэлдэхэд томоохон түлхэц өгсөн тэмцээн болж байна."

ДДЭШТВ ХХК -ны техник,
технологийн албаны захирал
Н.АРИУНБОЛД



КАНСАТ БА БУЦАГЧ

» Агаар, сансар, газрын технологийг анхлан суралцах, ойлгох эхлэл юм.



TESKIQ БАГ
»TESKIQ баг илтгэлээ танилцуулаа



Шүүгчдийн багийн гишүүн
оролцогчдод зөвлөгөө өгч байна



HIGH TECH баг
» ШУТИС-ийн МХТС-ийн HIGH TECH баг өөрсдийн багийн илтгэлээ танилцуулж байна.

КАНСАТ-2023

Үндэсний VI тэмцээн

ШИЙДВЭРЛЭХ ЗАГВАРЫН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ 2023.05.18




ШИЙДВЭРЛЭХ ЗАГВАРЫН
ХЭЛЭЛЦҮҮЛЭГ НЬ АЛИВАА
СИСТЕМИЙН ХӨГЖҮҮЛЭЛТИЙН
ҮР ДҮНД ЯМАР БҮТЭЭГДЭХҮҮН
БИЙ БОЛОХЫГ **ТУРШИЛТ,
БАРИМТ, НОТОЛГООГООР**
ЭЦЭСЛЭН ХАРУУЛНА.

ШЗХ

» Шийдвэрлэх загварын
хэлэлцүүлэгт шүүгч нар
болон оролцогчид



Тэмцээний Шийдвэрлэх Загварын хэлэлцүүлэг (Critical Design Review / CDR) нь 2023 оны 5-р сарын 18-ний өдөр Мэдээллийн технологийн паркийн хурлын танхимд болов. Урьдчилсан загварын хэлэлцүүлгийн адил багууд шүүгч нарт болон бусад оролцогчдод өөрсдийн хийж буй кансат болон буцагчийн тухай илтгэж асуултуудад хариулав. ШИЙДВЭРЛЭХ ЗАГВАРЫН ХЭЛЭЛЦҮҮЛГЭЭР тэдний хийж буй бүтээлийн прототип гарсан байх бөгөөд хөөрөх үеийн болон ажиллах үеийн орчны туршилтуудыг гүйцэтгэсэн байх ёстой. Улмаар тест туршилтын үр дүнг илтгэл болон техникийн баримт бичигтээ оруулсан байх ёстой юм.



ИНЕНЕРИЙН ЗАГВАР

» Зарим багууд өөрсдийн бүтээж
буцагчийн инженерийн загварыг
авч ирэв.



ИЛТГЭЛ

» Багууд өөрсдийн хийсэн
туршилтууд, болон үр дүнгээ
илтгэж байна



№	КАНСАТ ТӨРӨЛ	УЗХ-ийн оноо	ШЗХ-ийн оноо	Хөгжүүлэлтийн явцын нийлбэр оноо
1	Tomujin	12	13.06	25.06
2	iMED Technologies	13	12.36	25.36
3	SAMS	9.5	11.13	20.63
4	NewSpace	14	13.90	27.90
5	Gaint	12.3	14.16	26.46
6	Аравт	13.8	12.00	25.80
7	High Tech	13.1	14.23	27.33
8	Voyager 0	12.8	14.53	27.33
9	Gravity Falls	11	11.30	22.30
10	Teskiq	11	10.76	21.76
11	Моко	11.8	12.93	24.73
12	Цахилгаан пуужин	5.5	-	5.50
13	WeLome	11.7	-	11.70

№	БУЦАГЧ ТӨРӨЛ	УЗХ-ийн оноо	ШЗХ-ийн оноо	Хөгжүүлэлтийн явцын нийлбэр оноо
1	Gravity falls	12.10	12.46	24.56
2	iMED Technologies	-	-	-
3	PI23	14.30	13.50	27.80
4	WeLome	12.60	-	12.60
5	Gaint	-	-	-
6	NUMSAT	14.30	13.60	27.90
7	Аравт баг	13.30	13.10	26.40
8	High Tech	14.00	14.83	28.83
9	Моко	10.80	5.60	16.40
10	NewRobo	10.80	13.06	23.86



TESKIQ БАГ

» Монгол Коосэн Технологийн Коллежийн багийнхан илтгэлээ хэлэлцүүлж байна.



ШУТИС - ЭХС
iMED Technologies баг
» Багийн илтгэлийг танилцуулахад бэлэн.

КАНСАТ 2023 ШЗХ

» КАНСАТ 2023 тэмцээнд оролцогчид бусад багийн илтгэлийг сонсож байна.



GIANT баг

» ШУТИС-ийн МехТС-ийн GIANT баг өөрсдийн багийн илтгэлээ танилцуулж байна.

МУИС-ШУС


PI23



М.АЛТАНСҮХ

Багш, МУИС-ШУС-Физикийн тэнхим

Удирдагч багш




БУЦАГЧИЙН 3D ЗУРАГ

» Нийт масс: 1000 г

Г. БҮРЭНХАНГАЙ

МУИС-БУС Физик-3

Багийн ахлагч Механик их биеийн
загвар гаргах зурах,



Б.МАРАЛ

МУИС-БУС Физик-3

Механик загвар, шүхэрнээс салах
механизм



Л.МЭНД-АМАР

МУИС-БУС Физик-2

Элмент болон бусад зүйлсийн 3D
зураглал гаргах, бичиг баримт бэлтгэх



Б.МАРГАД

МУИС-БУС Биохими

Механик загвар, шүхэрнээс салах
механизм



Б.ХОНГОРЗУЛ

МУИС-БУС Физик-2


Механик загвар, шүхэрнээс салах
механизм



ДААЛГАВРЫН ЗОРИЛГО:

- ЦОЙЛУУРААС САЛААД АЮУЛГҮЙ ГАЗАРДАХ
- ӨГӨГДСӨН ЦЭГТ АМЖИЛТТАЙ ОЧИХ

Даалгаварт хоёр дугуйтай ровер ашиглана. Ровер цойлуураас салахад шүхэр дэлгэгдэх ба шүхэртэйгээ газардана. Аюулгүй газардсаны дараа нихрон утсыг халаан, шүхрийн бэхлэгчийг буцагчаас салгана. Шүхрээс салах механизмын овор хэмжээ, жинг бага байлгах үүднээс нихрон утас ашигласан. Шүхрээс салсны дараа GPS ашиглан байршлаа тогтоох ба 10 секундийн турш урагшаа явж дахин байршлаа тодорхойлон өмнөх цэг, одоогийн цэг болон өгөгдсөн 3 цэгийн координат ашиглан роверийн байрлалыг тодорхойлж өгөгдсөн цэг рүү чиглэнэ.







COMM	GPS BLE	→ NEO-6M → NINA-B306
EPS	Баттери Хүчдэл тогтворжуулагч Микро түлхүүр	→ Li-ion battery → LM → G-12AP
C&DH	On-board Computer Optocoupler	→ nRF52840 → pc817
Drive/ Steering motor	Motor driver Motor	→ L293d → 5V DC motor
MISN	Санах ой Rotary encoder	→ MicroSD Card

Буцагчийн дэд системүүд:

- Мэдээлэл дамжуулах модуль (COMM)
- Тэжээлийн систем (EPS)
- Комманд ба Өгөгдөл харьцах хэсэг (C&DH)
- Моторын удирдлага жолоодлогын хэсгүүд
- Даалгавар биелүүлэхэд зориулагдсан хэсгүүд


ТЭРГҮҮН БАЙР

» МУИС - ШУС PI-23 баг шагнал гардуулах ёслолын үеэр




Эрчим хүчний зарцуулалт

» Буцагчийг илүү удаан, тогтвортой ажиллуулахын тулд баттерины хүчдэлийг buck converter ашиглаж бууруулж хэрэглэсэн.



» Buck converter-ийн хүчдэл, гүйдлийг хэмжих замаар хувиргалтын ашигт үйлийн коэффициентийг тодорхойлох туршилт гүйцэтгэсэн. Энэхүү туршилтаар 3.7V батареийг тус бүр 3 цуваа энэ хоёр нийлээд зэрэгцээ 11.1V, тус бүр 2 цуваа энэ хоёр нийлээд зэрэгцээ 7.4V байхаар хэмжсэн. Ингэхэд 7.4V баттерины ашигт үйлийн коэффициент өндөр байна.



МУИС-ШУС




NUMSAT



Г. Дашням


» МУИС-ХШУИС-Электроник-4
» Багийн чиглүүлэгч багш
Техникийн зөвөлгөө өгөх



О. Гэрэлтнаран

» МУИС-БУС Физик-3

Багийн ахлагч, Программ хангамж



БУЦАГЧИЙН 3D ЗУРАГ

» Нийт масс: 880 гр
» Диаметр: 13.0 см
» Урт: 21.5 см


БУЦАГЧИЙН ЗОРИЛГО:

Цойлуураар хөөрч тодорхой өндөрт хүрсний дараа цойлуураас салж амжилттай газардсаны дараа өгөгдсөн солбицол дээр богино хугацаанд хүрэх.

ДААЛГАВАР ГҮЙЦЭТГЭХ ЗАРЧИМ:

- Цойлуураар хөөрнө
- Цойлуураас салж, шүхрээ дэлгэнэ.
- Газардаад, шүхрээс сална
- Датагаа аваад заасан байрлал руу очно

Буцагч нь хоёр дугуйтай, их биеийн хэсэгт хоёр мотор, моторын удирдлага, микроконтроллер, батарей болон шүхрээс салах системийн хэлхээ багтана.



Б. Болорцэцэг

» МУИС ХШУИС Электроник-2
» Электроник



Б. Болорцогт

» МУИС ХШУИС Электроник-2
» Их биеийн бүтэц, механик




Д. Булгантамир

» МУИС-ШУС- БУС-2
» Механик их биеийн загвар,
Газардах систем





Б. Хишигсүрэн

» МУИС Физик-1
» Механик загвар, программ



СИСТЕМЫН ЕРӨНХИЙ ДИЗАЙН

» Буцагч системд 2 микроконтроллер ашигласан. Эдгээр микроконтроллерууд нь GPS датаг хүлээж авч хэрэгцээтэйг ялган дамжуулах болон датаг боловсруулж моторыг удирдах алгоритмыг тооцох үүрэгтэй. Шүхрээс сервомотор ашиглан сална. Буцагчийн эргэлт, чиглэл хазайлтыг моторын эргэлтийг тоолох энкодер ашиглан шийдсэн.



$$R = \frac{1}{2} D \rho A v^2$$


$$A = 2.2 \text{ m}^2$$

$$v_t = \sqrt{\frac{2mg}{D\rho A}}$$


$$v_t = 3 \text{ m/s}$$



» Газардуулах систем, шүхэр, шүхрээс салах систем болон тооцооллын хэсгээс




АРДУИНО ХАВТАН ДЭЭРХ АТМЕГА 328Р МИКРОКОНТРОЛЛЕР НЬ МЭДРЭГЧҮҮДЭЭС ХҮЛЭЭН АВСАН МЭДЭЭЛЛҮҮДЭД ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙН РОВЕРИЙГ ЗӨВ ЧИГЛЭЛД ЯВУУЛНА



БУЦАГЧ ЗААСАН СОЛБИЛЦОЛД ОЧИХ АЛГОРИТМ:

Буцагч анх хаашаа харж байгаагаа мэдэхгүй учир анхны байрлалын мэдээллийг хадгалаад, чигээрээ тодорхой хугацаанд яваад 2 мэдээллийг ашиглаж доорх томъёо, схемийг ашиглаж харсан чиглэлээ олно. Ингэхдээ зөвхөн нэг дугуйг эргүүлэх замаар эргэж чиглэлээ өөрчилж явна. Arduino программ дээр алгоритмын хөгжүүлэлтийг хийсэн.

РОВЕРИЙГ ТЭНЦВЭРТЭЙ НЭГ ЧИГЛЭЛД ХАРУУЛЖ БАЙХ ЗОРИЛГООР СҮҮЛ БУЮУ ТЭНЦВЭРЖҮҮЛЭГЧ ХИЙСЭН



» Буцагчийн цахилгаан хэлхээний зураг. Ардуино төхөөрөмж болон мотор драйвер батарейтай холбогдоно. Бусад төхөөрөмжүүд ардуиногоос тэжээлээ авна.



ДЭД БАЙР

» МУИС - ШУС NUMSAT баг шагнал гардуулах ёслолын үеэр

ШУТИС-МХТС

HIGH TECH



Б.БАТ-ЭРДЭНЭ

Удирдагч багш


ШУТИС-МХТС багш



А.ДАВААСҮРЭН

Багийн ахлагч

Электрон схем, программчлал,



Л.ТҮВШИНБАЯР

Мэдээллийн систем 2-р курс

Механик дизайн




Э.СУМЬЯАБАЗАР

Электроник 3-р курс

Газардуулах систем



**ДРОНООР ДЭЭШ ГАРСАН БУЦАГЧ ГАЗАРДАХ ТӨХӨӨРӨМЖӨӨР
ГАЗАРТ БУУЖ, ГАЗАР ДЭЭР БАЙРЛАХ ӨГӨГДСӨН СОЛБИЦОЛ ДЭЭР
ХАМГИЙН БОГИНО ХУГАЦААНД ХҮРНЭ.**

Бидний дэвшүүлсэн эхний санаа нисэх онгоц загвар нь газрын бартаа саадыг харгалзахгүйгээр тодорхойлогдсон цэгт очих боломжтой ч цаг агаарын зарим нөхцөл байдалд даалгавар гүйцэтгэх боломжгүй байсан тул бид газраар явах шийдлийг сонгосон.



» Нисэх онгоц загвар


Бид Mars ровероос санаа авч явах төхөөрөмж хийхээр шийдсэн бөгөөд энэ загвар нь газрын бартаа, саадыг цаг агаарын аль ч нөхцөлд туулан тодорхойлогдсон цэгт очих боломжийг бүрдүүлсэн.



» УЗХ-т дэвшүүлсэн санаа. Энэхүү загвар нь саад давах болон эвхэгдэх явцад асуудлууд гарч байсан учир буцагчийн ерөнхий бүтцэд өөрчлөлт оруулж гинжит дугуйт загварыг бүтээсэн.

ДААЛГАВРЫН ТОЙМ



Цойлуураас контейнер салах үед шүхэр дэлгэгдэх ба мэдрэгчийн тусламжтай газраас 50см өндөрт ирэхэд контейнер дэлгэгдэж буцагчийг доош орхино. Контейнер дэлгэгдэхийн тулд серво моторыг ажиллуулна. Буцагч контейнероос аюулгүй салж газардсаны дараа GPS ашиглан байршлаа тогтоох ба байршлаа тодорхойлон өмнөх цэг, одоогийн цэг болон өгөгдсөн 3 цэгийн координат ашиглан буцагчийн байрлалыг тодорхойлж өгөгдсөн цэг рүү чиглүүлнэ. Буцагч хөдөлж буй эсэхийг мэдрэгч байнга шалгах ба хэрэв хөдлөхгүй бол саад таарсан гэж үзэн саадыг тойрно.




» Механик бүтцийн дизайн, 3D загварын хэсгээс

ГАЗАРДУУЛАХ СИСТЕМ

ГАЗАРДУУЛГЫН ХУВЬД ШИЙДВЭРЛЭХ ЭЦСИЙН ЗАГВАРТ ӨНДӨР ЧАНГААХ ХҮЧНИЙ КОЭФФИЦИЕНТ БАЙХ ТАЛЫГ БАРИМТЛАН ДООРХ ЗУРАГТ ҮЗҮҮЛСЭН КРОСС ХЭЛБЭРИЙН ШҮХРИЙГ СОНГОСОН. ЭНЭ НЬ МАНАЙ БУЦАГЧИЙГ УЛАМЖЛАЛТ БАЙДЛААР ГАЗАРДАХ ШИЙДЭЛ ЮМ.



» Буцагчийн PCB хавтан





Component	Source	Voltage (V)	Current (mA)	Power	Power Consumption (Wh)	Duty Cycle
TB6612FNG	Datasheet	5V	1200mA	6w	6	100%
Yellow motor(2x)		3-9V	200mA	1.8*2=3.6w	1.8	100%
Ultrasonic	Datasheet	5V	15mA	0.075w	0.075	100%
Arduino nano every	Datasheet	7-12V	50mA	0.6w	0.6	100%
NEO 6M	Datasheet	3.3V	45mA	0.148w	0.148	100%
Mini IMU-9 v5	Datasheet	5V	5mA	0.025w	0.025	100%
TOTAL				10.445W	10.445W	
SONY VTC5D Battery		7.4V	2200mA		16.280 Wh	
TIME					1 hour 30 minutes	

Үзүүлэлт	Хэмжээ
Буцагчийн урт	215мм
Буцагчийн өргөн	100мм
Буцагчийн масс	600gr
Контейнер масс	300gr
Батерейны тооцоолсон ажиллах хугацаа (үндсэн даалгавар)	1 цаг 30 минут
Буцагчийн өртөг	311,580 ₮

ШАГНАЛ

» High Tech баг Кансат 2023 тэмцээний буцагчийн төрөлд 3-р байр эзлэв



Бид бүтцийн дизайнаа "Solid works" программ дээр зурсан




» Буцагчийн бодит зураг




ҮБХИС АРАВТ

ДААЛГАВРЫН ТОЙМ

Даалгаварт газраар явагч эсвэл нисэх загварын ровер ашиглана. Ровер цойлуураас салахад шүхэр дэлгэгдэх ба шүхэртэйгээ газардана. Газардсаны дараа шүхэрнээс салах систем ажиллана. Аюулгүй газардсаны дараа GPS ашиглан байршлаа тогтооно. Буцагч өөрийн газардсан цэгээс явж дахин байршлаа тодорхойлон өмнөх болон одоогийн байршлын координат, өгөгдсөн цэгийн координатуудыг ашиглан роверийн явах зүгийг тодорхойлж өгөгдсөн цэг рүү чиглүүлнэ.



» Нийт масс: 808 г
» Диаметр: 13.0 см
» Урт: 22.5 см



№	Сэлбэг хэрэгслийн нэр	Тоо, ширхэг	Нэгж үнэ	Нийт үнэ
1	Микроконтроллер	1	40.000	40.000
2	Байршил заагч	1	70.000	70.000
3	Мотор удирдлага	1	10.000	10.000
4	Хүчдэл тогтворжуулагч	1	7.700	7.700
5	Луужин	1	35000	35000
6	Хазайлт хэмжигч	1	9000	9000
7	Мотор	2	145.000	290.000
8	3D printer filament	1	80.000	80.000
9	Шүхэр	1	20.000	20.000
10	Серво мотор	1	7.000	7.000
11	Эр, эм утас	1	50.000	50.000
12	Тэжээлийн үүсгүүр	1	40.000	40.000
13	Sil /хөл/	50	500	25.000
14	Тугалга	1	80.000	80.000
15	Зүлгүүр	3	2.000	6000
16	Шохойтой цаас	1	11.000	11.000
17	Өрөм	5	300	1.500
18	Зэс хавтан	2	10.000	10.000
19	Нийт			797.200

» "БУЦАГЧ" бичил хиймэл дагуул бүтээх сэлбэг хэрэгслийн үнийн жагсаалт

"БИЧИЛ ХИЙМЭЛ ДАГУУЛ ЗОХИОН БҮТЭЭН ЦЭРГИЙН ЗЭВСГИЙН БОЛОН ТЕХНИКИЙН ЗОРИУЛАЛТТАЙ

ХОСЛУУЛАН АЖИЛЛУУЛАХ НЬ БИДНИЙ ЗОРИЛГО ЮМ.



Л. БЯМБАЖАРГАЛ
УДИРДАГЧ БАГШ
Программ



А. БАЯННАМСРАЙ
Ф-408
Электроник



Ж. БУЯННЭМЭХ
Ф-408
Программ



Г. ГАНБАЯР
Зинет артиллерийн команд
Механик





Буцагчийн даалгавар биелүүлэх алгоритм


ДЭД СИСТЕМИЙН СХЕМ

Микроконтроллер нь тэжээлийн үүсгүүрээс хүчдэл бууруулагчаар дамжуулан хүчдэлийг багасган тэжээлийг авч байршил тогтоогч, мотор удирдлага зэрэг элементүүдэд мэдээлэлийг боловсруулан дамжуулна.

БУЦАГЧИЙН 3D ЗАГВАР



БУЦАГЧИЙН БОДИТ ЗУРАГ




ӨГӨГДСӨН СОЛБИЦОЛД ХҮРЭХ НЬ

ХҮ цэгт буцагч газардаж дурын зүгт эгц урагш a замын хэмжээнд явж X_1Y_1 цэгт очиж GPS-ийн өгөгдлийг авна. Тэгснээр өргөрөг уртрагуудын хооронд шулуун үүсгэн өнцгийг олж эргэх зүгээ тодорхойлж өгөгдсөн цэг рүү чиглэнэ явна.

Тооцоо » Бид явах замаа тооцохдоо "Cosinus theorem" ашигласан

- xu – Газардах цэгийн координат
- x_1y_1 – Очих цэгийн координат
- b – Очих цэг хүртэлх уртраг, өргөрөг хоорондын зай
- c – Очих цэг хүртэлх уртраг, өргөрөг хоорондын зай
- a – Очих цэг хүртэлх туулах зай



№	Модулын нэр	Нэр	Жин
1	Микроконтроллер	Arduino NANO	5.6 гр
2	Байршил заагч	GPS NEO-6M	1.7 гр
3	Луужин	LSM303D 3D compass	1.8 гр
4	Хазайлт хэмжигч	Gy-521	1.4 гр
5	Мотор удирдлага	TB6612FNG	1.8гр
6	Хүчдэл тогтворжуулагч	LM2596	9.5гр
7	Мотор 2 ширхэг	Мотор: 9.7:1 Metal Gearmotor 25Dx48L mm	415 гр
8	Дугуй 2 ширхэг	Дугуй Small Wheel 66D	145 гр
9	Их бие болон хавтан	Plate	110 гр
10	Серво мотор 1 ширхэг	Plastic gear SG90	9 гр
11	Тэжээлийн үүсгүүр	(Engpow-7.4V1200mAh)	108 гр
12	Нийт		808.8 гр

» Буцагч системийн жингийн тооцоо

№	Модулын нэр	Хүчдэл	Гүйдэл	Чадал
1	Микроконтроллер (Arduino NANO)	5 v	20 mA	100 mW
2	Байршил заагч (GPS NEO-6M)	5 v	45mA	225 mW
3	Мотор удирдлага (TB6612FNG)	5 v	5 mA	25 mW
4	Хүчдэл тогтворжуулагч (LM2596)	7.4 v	22.2 mA	164.28 mW
5	Мотор 2 ширхэг (9.7:1 Metal Gearmotor 25Dx48L mm)	12 V	250 mA	3W
9	Серво мотор 1 ширхэг (Plastic gear SG90)	5 V	25 mA	125 mW
11	Нийт			3.64 W

» Буцагч системийн чадлын зарцуулалт




NEW ROBO

"ӨӨРИЙН ГАРААР УЛСАА БҮТЭЭНЭ"

ДААЛГАВРЫН ЗОРИЛГО

- Цойлуурт хийсэн Ровер нь хөөрөх зорилтот өндөрт гарсны дараагаар чөлөөтэй унах явцдаа шүхрээ дэлгэж тогтвортой бууж даалгавраа гүйцэтгэнэ. Даалгаврын зорилгын хүрээнд өөрийн байгаа байршил буюу уртраг, өргөрөг мэдээллийг хугацаанаас хамааруулж хадгалах. Үүний үр дүнд өгөгдсөн солбицолд хүрнэ.
- Мөн газардах үеийн роверын 3 тэнхлэгийн хурдатгал, өнцөг хурд, соронзон орны урсгалыг хугацаанаас хамааруулан хадгална. Улмаар роверын эргэлдэх, давших, ямар өнцгөөр хазайж буй хөдөлгөөнийг тандах боломжтой болно.



Б. СУМЬАБАЗАР
ЧИГЛҮҮЛЭГЧ БАГШ

ДААЛГАВРЫН ТОЙМ

Ровер төхөөрөмж нь цойлуураас тодорхой өндөрт хүрч салахдаа шүхрээр газардана. Газарт буугаад үндсэн даалгавар буюу өгөгдсөн солбицол руу явахдаа гадна өнцөг хурдатгал болон газрын солбицлын мэдээллийг SD картад хадгална. Дугуйг 3D-ээр хэв хийж силиконыг халааж хийнэ. GPS сенсрын тусламжтай үндсэн даалгавар болох өгөгдсөн солбицол болон өөрийн солбицлыг тодорхойлон микроконтроллерыг ашиглаж өгөгдлөө боловсруулан тооцоолол хийнэ. Уг тооцооллын үр дүнд мотор драйверыг удирдан 2 моторын чиглэл болон эргэлтийн хурдыг тохируулна.



С.ЦАЦРАЛ
ПРОГРАМЧЛАЛ,
ХЭЛХЭЭ УГСРАЛТ
Цахилгаан
электроникийн
инженер



Э.БАТЦЭНГЭЛ
БАГИЙН АХЛАГЧ
Цахилгаан
электроникийн
инженер



М.БУЯЭТОГТОХ
ПРОГРАМЧЛАЛ,
МЕХАНИК ХИЙЦ
Цахилгаан
электроникийн
инженер



Г.ХУВЬТӨГӨЛДӨР
ПРОГРАМЧЛАЛ,
ХЭЛХЭЭ УГСРАЛТ
Цахилгаан
электроникийн
инженер



М. БИЛГҮҮН
МЕХАНИК ХИЙЦ,
ХЭЛХЭЭ УГСРАЛТ
Цахилгаан
электроникийн
инженер



М.БУЯНДЭЛГЭР
ПРОГРАМЧЛАЛ,
ХЭЛХЭЭ УГСРАЛТ
Цахилгаан
электроникийн
инженер



Ч.ЭРДЭНЭБИЛЭГ
МЕХАНИК ХИЙЦ,
ХЭЛХЭЭ УГСРАЛТ
Цахилгаан
электроникийн
инженер




С.УЛСБОЛД
МЕХАНИК ХИЙЦ,
ХЭЛХЭЭ УГСРАЛТ
Цахилгаан
электроникийн
инженер



Г.ГАНДИР
ТӨЛӨВЛӨГӨӨ, БИЧИГ
БАРИМТ
Цахилгаан
электроникийн
инженер




Б.ДАГИЙЖАНЧИВ
ПРОГРАМЧЛАЛ,
ХЭЛХЭЭ УГСРАЛТ
Цахилгаан
электроникийн
инженер




» Буцагчийн системийн блок диаграм

Дугуйн зөөлөвчийг 3D принтерээр хэв гаргаж, силиконоор шахаж хийнэ. Энэ нь буцагч шүхрээр газардах болон саадыг давах үеийн доргилтыг багасгах зорилготой.




БИД БҮРЭЛДЭХҮҮН ХЭСЭГ БҮРИЙН ФИЗИК ХЭМЖЭЭСҮҮД БОЛОН ЦАХИЛГААН ХЭЛХЭЭНИЙ ШААРДЛАГЫГ ХАРГАЛЗАН АВСААРХАН ЗОХИОН БАЙГУУЛАЛТТАЙ ДИЗАЙНЫГ БИЙ БОЛГОСОН.

“БИД **АНХ УДАА** БУЦАГЧ ТӨРӨЛД ОРОЛЦОЖ БАЙГАА. ИЙМД ТЭМЦЭЭНД БЭЛТГЭХИЙН ТУЛД **БАГ ХАМТ ОЛНООРОО** ИНТЕРНЕТ БОЛОН БУСАД ПЛАТФОРМУУДААС ТАНДАЛТ, СУДАЛГАА ХИЙЖ **ИЛҮҮ ХҮЧИН** ЧАДАЛТАЙ, ШИНЭ ҮЕИЙН, МӨН БУЦАГЧ-РОБЕРТ АШИГЛАХАД ТОХИРОМЖТОЙ **ЗАГВАРУУДЫГ** ХООРОНД НЬ **ХАРЬЦУУЛЖ**, ТҮҮН ДОТРООС СОНГОЛТОО ХИЙСЭН.



МИКРОКОНТРОЛЛЕР

ESP-32 нь Espressif Systems-ийн бүтээсэн олон талт микроконтроллер ба WiFi/Bluetooth систем дээрх чип (SoC) модуль юм. Энэ нь микроконтроллерийн нэгжийн (MCU) хүчийг нэгдсэн Wi-Fi болон Bluetooth боломжуудтай хослуулсан бөгөөд үүнийг интернетийн зүйлсийн (IoT) програмуудад түгээмэл сонголт болгодог.



Газардуулах систем

Хөндлөн шүхэр нь агаарын даралтыг халхавчаар жигд хуваарилснаар буух үед тогтвортой байдлыг бий болгодог.

Үзүүлэлт	Хэмжээ
Буцагч роботын өндөр	227мм
Буцагч роботын диаметр	117мм
Буцагч роботын масс	737гр
Шүхрийн масс	328гр
Тооцоолсон унах хурд	3,5м/с
Батерейн тооцоолсон ажиллах хугацаа (үндсэн даалгавар)	37минут
Буцагч роботын туулах замын тооцооны утга	2,4км

» Буцагчийн үзүүлэлтүүд



» Тэмцээнд оролцоход бэлэн болсон ровер





» Тэмцээний талбайд бэлэн байдлаа хангаж байна



ШАГНАЛ

» New Robo баг тусгай байрын шагнал хүртлээ

ШУТИС - МХТС



БУЦАГЧИЙН 3D ЗУРАГ

» Нийт масс: 950 гр

» Диаметр: 13.0 см



Б. Пүрэврэнцэн

» Др. дэд профессор
» Удирдагч багш



Б. Жавхлантөгс

» Зөвлөх багш



Г. Дагва

» Багийн ахлагч, Электроник-3
» Угсралт, механик



Х. Есөн-Эрдэнэ

» Утасгүй холбоо - 2
» 3D дизайн



Н. Бишрэл

» Утасгүй холбоо-2
» Газардах систем



А. Алтанбагана


» Робот, хиймэл оюун - 3
» Холболт

ДААЛГАВРЫН ЗОРИЛГО:

- Цойлуураар дээш хөөрсөн буцагч газардсны дараа газар дээр байрлах тодорхой солбилцол дээр хамгийн богино хугацаанд дөхөж очих.
- Саад мэдрэгч (Yellow sensor), Байршил тогтоогч (Ublox neo 6m GPS module) мэдрэгчүүдийн ажиллагааг шалгаж, мэдрэгчүүдээс авсан өгөгдлийг боловсруулж хөдөлгүүрийг удирдах.
- Мэдрэгчүүдээс авсан өгөгдлийг хурдтай боловсруулж хөдөлгүүр богино хугацаанд зөв хариу үйлдэл үзүүлэх

ДААЛГАВРЫН ТОЙМ:

- Буцагч нь заасан цэгт очихын тулд байршил тогтоогч (Ublox neo 6m GPS module) ашиглан өөрийн байршлыг очих цэгтэй харьцуулан явах чиглэлээ тодорхойлно.
- Буцагчийн явах замд саад байвал саад мэдрэгч (Yellow sensor) нь 5 метрийн зайд байх саадыг мэдэрснээр буцагч саадыг тойрч явна.
- Моторын удирдлага (Motor driver TB-6612FNG) ашиглан моторын эргэлтийг удирдана.



СХЕМ

» Буцагчийн ерөнхий архитектур

	Төхөөрөмжийн нэр nano	Хэрэглэгдэх шаардлага	ширхэг
			1
	E18-D50NK sensor /yellow sensor/	Саад мэдрэгч ойрын 5 метрт байх саадыг мэдрч уг зайг nano луу илгээнэ.	1
	Servo motor	Шүхэрнээс салахад тасдагчийг хөдөлгөх.	1
	Bluetooth module		1
	Ublox neo 6m GPS module	Байршил тогтоогч нь буцагчийн координатын цэгийг буцаана.	1
	TB6612FNG motor driver	Моторын эргэлтийг зохицуулна.	1
	Lion battery 12V 1000mA 7.4V 1200mA 3.7V 1000mA	Тэжээл өгөх. /Серво, нано болон motor driver -т тэжээл өгөх/	4
	Motor		2
	Дугуй		2
	Switch	Асаах, явах switch	2

Элементийн жагсаалт

» Gravity Falls багийн буцагчийг бүтээхэд орсон нийт элементийн дэлгэрэнгүй жагсаалт




» Буцагчийн их биеийн загвар




Газардуулах систем

Бид шүхрийн материалыг сонгохдоо салхинд тэсвэртэй байдал, уян хатан чанар, хөнгөн, элэгдэлд тэсвэртэй, хямд зэрэг онцлогуудыг харгалзан үзэж нейлон материалыг сонгосон.



Бид буцагчийн туршилтын загварыг bread board дээр бүтээн туршсан



Буцагч

» Буцагчийг бодитоор угсарсан байдал



**АЛИВАА ХИЙМЭЛ ДАГУУЛ, САНСРЫН ХӨЛӨГ НЬ ХӨӨРГӨГЧ ЦОЙЛУУРТ
БАЙРЛУУЛАХААС ӨМНӨ ХӨӨРГӨГЧИЙН ШААРДЛАГА, АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ
ХАНГАЖ БАЙГААГ "SAFETY REVIEW" БОЛОН "FLIGHT READINESS REVIEW"-
ЭЭР ШАЛГУУЛЖ ХӨӨРӨХ ЗӨВШӨӨРӨЛ АВДАГ.**

ХӨӨРӨХ БЭЛЭН БАЙДАЛ

НББУ

» Нисэх Бэлэн Байдлын
Үзлэгийн (НББУ) үеэр



АСТРОПАРК

САНСАР ОД ЭРХЭСИЙН ОРДОН

НББУ нь тэмцээний хамтран зохион байгуулагч
ШУА-ийн Одон Орон Геофизикийн Хүрээлэнгийн
Сансар Судлалын төвийн Астропарк дээр болов.

Тэмцээн оролцогчид бүтээлүүдийнхээ нисэх
бэлэн байдлыг шалгуулахын зэрэгцээ сансрын
музей үзэж сонирхов.



ХЭМЖИЛТ

» НББУ-ийн үеэр Буцагчийн
массыг шалгаж байна

**МАСС БА ОВОР ХЭМЖЭЭ БОЛ ХАМГИЙН
ЧУХАЛ ШАЛГУУР ЮМ. ЖИЖИГ
ХЭМЖЭЭНД ХЭРХЭН БҮХ СИСТЕМЭЭ
БАГТААХ ВЭ? ГЭДЭГ ХЭЦҮҮХЭН СОРИЛТ
ТУЛГАРНА.**

КАНСАТ болон БУЦАГЧ-ийг хөөргөх
цойлуур, Агаарын бөмбөлөг зэрэгт
ачааны масс болон овор хэмжээ маш
ихээр нөлөөлнө. Тиймээс тэмцээний
зохион байгуулагчид тэмцээний дүрэмд
хэмжээ болон бусад шаардлагуудыг
урьдчилан тодорхой заасан байдаг.

КАНСАТ 2023 тэмцээний хувьд "Нисэх
Бэлэн Байдлын Үзлэг (НББУ)"-ээр дээр
дурдсан шаардлагуудыг тэмцээнд
оролцогч багуудын бүтээсэн КАНСАТ
болон БУЦАГЧ -ууд хангаж байгааг
шалгасан юм.





НББҮ - 2023.06.15
 » Кансат тэмцээний аливаа хэлэлцүүлэг нь бие биеэсээ суралцаж авах сайхан боломж байдаг



**НИСЭХ БЭЛЭН БАЙДЛЫН
 ҮЗЛЭГ**
 » ШУА, ООГФХ-гийн Сансар
 судлалын Төв, Астропарк








АНХНЫ ЭМЭГТЭЙ САНСРЫН

**Ж.ГУРРАГЧАА**


МОНГОЛ УЛС, ЗХУ-ЫН БААТАР,
МОНГОЛ УЛСЫН САНСРЫН
НИСЭГЧ Ж.ГУРРАГЧАА

Манай залуучуудын дунд Кансат буюу лаазан дагуулын тэмцээн явагдаж, залуус их өргөн хүрээтэй оролцох болсон. Аймаг, хөдөө орон нутгаас нэлээд олон багууд ирж өрсөлдөх бололтой байна. Бид зөвхөн дотооддоо өөрсдөө юм хийгээд, суралцаад зогсохгүй энэ чиглэлээр гадаад улс орнуудад хийгдэж буй ажлуудаас суралцах, технологийг нь эзэмших ажлууд давхар хийгдэж байдгийг бас хэлмээр байна. Энэ нь залуучуудын техник сэтгэлгээг хөгжүүлж бие биеэсээ суралцахад чухал алхам болно гэж үзэн, шинжлэх ухааны байгууллагууд болон яам тамгын газруудаас боломжийн хэмжээгээр дэмжиж байгаа.


Одоогоос 60 жилийн өмнөх 6-р сарын 16-ны өдөр дэлхийн анхны эмэгтэй сансрын нисэгч Валентина Терешкова сансарт нисэж байсан. Иймээс бидний тэмүүлж буй тэмүүлэл, хүрэх гэж зорьж буй газар сансар учраас Кансат 2023 тэмцээнээ энэхүү билэг дэмбэрэлтэй өдрийг сонгон зохион байгуулж байна.



НИСЭГЧ САНСАРТ НИССЭНИЙ 60 ЖИЛИЙН ОЙД




ШУТИС-MХТС HIGHTECH



КАНСАТЫН 3D ЗУРАГ

»Кансатын бүтэц, элемент мэдрэгчүүдийн байрлал



Л.АНУЖИН

БАГИЙН АХЛАГЧ
Чиглэл: Мэдээллийн систем 3-р курс
Газрын станц, холбооны систем, антенн



З.УЛАМБАЯР

БАГИЙН ГИШҮҮН
Элетроник 3-р курс
Электрон схем, PCB дизайн, хүлээн авагчийн програм



Д.Хүслэнбаяр

БАГИЙН ГИШҮҮН
Утасгүй холбоо 3-р курс
Газардуулах систем, техник хангамж



Ч.БАТЧУЛУУН

УДИРДАГЧ БАГШ
ШУТИС-MХТС -ийн холбооны салбарын ахлах багш

КАНСАТЫН ЗОРИЛГО

Нислэгийн үеийн агаарын температур, чийгшил, даралтыг хэмжин хадгалах, хадгалсан мэдээллийг газрын станц уруу дамжуулах. Нэмэлтээр хорт газны түвшинг хэмжин тухайн орчныг үл мэдэгдэх гариг буюу эсвэл бусад аюултай байж болзошгүй орчин хэмээн төсөөлөн тухайн орчинд амьд биет газардах, амьдрах боломжтой эсэхийг шалгах зорилгоор уг даалгаврыг баяжуулсан.

Цуглуулсан хэмжилтийн үр дүнгүүдийг ашиглан өмнөх жилийн тэмцээний үеэр хийсэн хэмжилтийн утгуудтай харьцуулан, дүн шинжилгээ хийнэ. Уг боловсруулалтаас хоёр жилийн өгөгдлүүдийн өөрчлөлт болон ирээдүйд цаг агаарын өөрчлөлтийг таамаглах оролдлого хийнэ. Уг даалгаврыг амжилттай болсон гэж үзэхийн тулд нислэгийн туршид 30-с доошгүй удаагийн хэмжилт хийн хадгалж, газрын станц руу дамжуулсан байна. Ингэснээр шаардлагатай боловсруулалтыг хийх сургалтын өгөгдөлтэй болно.

Дэд даалгаварт хоорондоо хамаарал бүхий хэд хэдэн жижиг даалгавруудыг дэвшүүлсэн. Уг дэд даалгаврыг амжилттай болсон гэж үзэхийн тулд Uplink ашиглан бээзер асаах, унтраах ажиллагаа амжилттай хэрэгжих, газарт буусныг мэдрэн босох үйлдлээ хийн, бусад хэмжилтийн өгөгдлүүдийг SD картанд хадгалан авсан байх шаардлагатай

ДААЛГАВРЫН ТОЙМ


Кансатыг цойлуурт асаан байрлуулснаар GPS хиймэл дагуултай холбогдох хугацааг хангана. Цойлуураас салсны дараа BME-280 мэдрэгч нь агаараас даралт, температур, чийгшил зэрэг үндсэн даалгаврын өгөгдлүүдийг цуглуулна. BME-280 мэдрэгч дэд даалгаврын өндөр, MQ-135 мэдрэгч газ болон хорт хийн түвшинг, Neo-6M модуль байршлыг (уртраг өргөрөг), MPU-6050 мэдрэгч хазайлтын өнцгүүдийг, Teensy контроллерын оролтын пинг ашиглан батареин хүчдэлийн түвшинг хэмжинэ. Хэмжсэн утгуудыг кансат SD карт руу бичин хадгалж, түүний дараагаар XBee Pro S1 модулийг ашиглан газрын станц руу илгээнэ. Нислэгийн хугацаанд газрын станцаас команд ирвэл тусгай thread ажиллан командыг гүйцэтгэнэ.

ШУТИС-MХТС-ИЙН HIGHTECH КАНСАТ БАГИЙН ХУВЬД NASA-ГААС ЗОХИОН БАЙГУУЛСАН ОЛОН УЛСЫН ТЭМЦЭЭНД ОРОЛЦСОН ТУРШЛАГУУДААС АА ШИНГЭЭН ЭНЭ ЖИЛИЙН КАНСАТАА БҮТЭЭСЭН.




ШАГНАЛ ГАРДУУЛАХ ЁСЛОЛ

» КАНСАТ төрөлд 2023 оны үндэсний 6-р тэмцээний аварга баг болов.



» Даалгаврын ерөнхий зураг



